БАЯНХОНГОР АЙМГИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЛИЙН ЦАХИМ САНГИЙН
ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

1. **Системийн ерөнхий шаардлага**

1.1.Mozilla Firefox, Google Chrome, Microsoft Edge, Safari зэрэг түгээмэл ашигладаг вэб хөтчүүд дээр системийн бүх функц болон загварууд зөрүүгүй ажилладаг байх;

1.2.Төрийн байгууллагуудын албан хэрэгт мөрдөгдөж байгаа компьютерийн кирилл болон монгол үсгийн нэгдсэн кодын MNS-5552:2005 стандартыг ашигладаг байх;

1.3.Цахим системийн админ болон хэрэглэгчийн тоог систем нэвтрүүлэлтийн явцад өөрчлөх боломжтой байх;

1.4.Цахим системийн бүх хэрэглэгчид нэгэн зэрэг ашиглахад систем ачаалал даах чадвартай байх

1.5.Төрийн байгууллагуудын албан хэрэгт мөрдөгдөж байгаа нэршил, нэр томъёо ашигласан байх;

1.6.Цахим системийг хэрэглэхэд хялбар, ойлгомжтой байх; (user friendly interface)

1.7.Системд нэвтрэхэд хэрэглэгчид мэдэгдэл (notification) очдог байх;

1.8.Системийн аюулгүй байдал, нууцлал хамгаалалтыг бүрэн хангсан байна. (SSL гэх мэт)

1.9.Мэдээлийн баазыг архивлах, архиваас нөхөж харах боломжтой байх;

1.10.Бүх хэрэглэгчдэд үндсэн болон дэд системүүдийн тайлан, мэдээ нь dashboard хэлбэрээр шууд харагддаг байх;

1.11.Цахим системийг ашиглах сургалтуудыг систем ашиглагч байгууллагуудад үе шаттайгаар бүрэн зохион байгуулна.

2.Доорх хууль, тогтоомжуудад бүрэн нийцсэн байна.

1.1. Монгол улсын хуулиуд:

1.1.1.Монгол Улсын Засгийн газрын тухай хууль

1.1.2.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль

1.1.3.Төсвийн тухай хууль

1.1.4.Төрийн албаны тухай хууль / Шинэчилсэн найруулга /

1.1.5.Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

1.1.6.Яамны эрх зүйн байдлын тухай хууль

1.1.7.Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль

1.1.8.Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль

1.1.9.Шилэн дансны тухай хууль

1.1.10. Авлигын эсрэг хууль

1.2. Засгийн газрын тогтоолууд:

1.2.1.Засгийн газрын 2021 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журам"

1.2.2.Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"

1.2.3.Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам"

1.2.4.Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"

1.2.5.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан "Аргачлал, загвар батлах тухай"

3.Үндсэн мэдээллийн сан

	НЭГ. ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖИХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ
1.	Алсын хараа – 2050
2.	Хөгжлийн зорилтот хөтөлбөр
3.	Монгол улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл
4.	Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөр
	ХОЁР. ОРОН НУТГИЙН ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖИХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ
5.	Аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл

6.	Аймгийн Засаг даргын Үйл ажиллагааны хөтөлбөр
7.	Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө
8.	Сумын Засаг даргын Үйл ажиллагааны хөтөлбөр
9.	Сумын хөгжлийн жилийн төлөвлөгөө
10.	Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт
11.	Сумдын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт
	ГУРАВ. ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ
12.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт
13.	Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын биелэлт
14.	Аймгийн ИТХ-ын тогтоол, ИТХТ-ын тогтоолын биелэлт
	ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ
15.	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт / Аймгийн Засаг дарга – АЗДТГ-ын дарга /
16.	Гэрээний биелэлт №1. Аймгийн Засаг дарга – Засгийн газрын гишүүн
17.	Гэрээний биелэлт №2. Аймгийн Засаг дарга – Засаг даргын дэргэдэх агентлаг, ОНӨҮГ
18.	Гэрээний биелэлт №3. Аймгийн Засаг дарга – Сумын Засаг дарга
19.	Аймгийн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт
20.	Сарын ажлын тайлан №1. АЗДТГ-ын дотоод бүтцийн нэгжүүд
21.	Сарын ажлын тайлан №2. Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, ОНӨҮГ
22.	Сарын ажлын тайлан №3. Сумын Засаг даргын Тамгын газар
	ТАВ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ
23.	Байгууллагын ил тод байдлын үнэлгээ
24.	Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ
	ЗУРГАА. ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ
25.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийн нэгжүүдийн үнэлгээ
26.	Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагуудын үнэлгээ
27.	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үнэлгээ
28.	Сумын Засаг даргын Тамгын газруудын үнэлгээ

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Л.МАНДАЛ

БОЛОВСРУУЛСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.БАТБАЯР